



**НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮЗЛЭГ,
БҮСЧИЛСЭН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

Тайлан бичсэн:

Т. Оюунбат /

Соёлын өвийн үндэсний төвийн бүртгэл, мэдээллийн санч

Улаанбаатар хот

2022 он

Энэхүү тайланг Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл Урлагийн газрын захилгаар “УЛААНБААТАР-НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮЗЛЭГ, СУДАЛГАА” сэдэвт ажлын хүрээнд хийж гүйцэтгэв.

Судалгааны багийн ахлагч: Т. Оюунбат (БМС, Соёлын өвийн үндэсний төв)

Судалгааны багийн гишүүд: О. Цэвэлмаа (Шинжээч, Соёлын өвийн үндэсний төв)

Г. Дамдинсүрэн (Үндэсний урлагийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Нийслэлийн соёл, урлагийн газар),

Ц. Наран-Эрдэнэ Соёл, урлагийн газрын сонгодог урлагийн асуудал хариуцсан мэргэжилтэн,

Жолооч: Ч.Гантулга

Гарчиг	
Удиртгал	
Судалгааны үндэслэл	4
Судалгааны ажлын зорилго	4
Судалгааны ажлын зорилт:	4
Судалгааны арга зүй.....	5
Судалгааны хамрах хүрээ	5
Нэг: Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчдын өнөөгийн байдал	8
1.1 СББӨ өвлөн уламжлагчийн угсаатны бүлгийн онцлог	10
1.2 СББӨ өвлөн уламжлагчдын нийгмийн асуудал	10
2. НИЙСЛЭЛИЙН СББӨ-Д ХИЙСЭН ЦАХИМ СУДАЛГААНЫ	
(GOOGLE FORMS) ҮЗҮҮЛЭЛТ	
2.1. Нийслэлийн СББӨ-д хийсэн судалгааны тоон үзүүлэлт	25
2.2. Нийслэлийн СББӨ-ийн ай, өвийн төрлүүдэд хийсэн судалгаа ...	26
2.3. Улаанбаатар хотын СББӨ-ийн судалгаанд оролцогчид, өвлөн уламжлагчид, товч танилцуулга /9-н дүүргээр/	32
ЗӨВЛӨМЖ	39
САНАЛ	40
НОМ ЗҮЙ	41


Удиртгал

Судалгааны үндэслэл

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн 27 дугаар зүйлийн 27.11 дэх хэсэг, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/235 тушаал, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, Соёлын сайдын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Зардал баталж, эрх шилжүүлэх тухай” А/218 дугаар тушаал, Засгийн газрын хэрэгжүүлэх агентлаг Соёл, урлагийн газрын даргын А/42 тоот тушаалыг үндэслэн “Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгаа” -г нийслэлийн 9 дүүрэгт зохион байгуулав.

Судалгаагаар соёлын биет бус өв (СББӨ)-ийн 6 ай савын хүрээнд дараах гурван асуудлыг авч үзэв.

СББӨ, ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ



Судалгааны ажлын зорилго

Өвийг өвлөн уламжлагчдийн өвийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах, тархалтыг тогтоож тодорхойлоход чиглэгдэнэ.

Судалгааны ажлын зорилт:

- 1) Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Бүртгэл шинэчлэн батлах тухай” 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/759 дүгээр тушаалаар баталсан Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл, Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд бүртгэгдсэн өв, өвлөн уламжлагчийн талаар түүвэр судалгаа хийх;
- 2) Тухайн орон нутагт оршин буй үндэстэн, угсаатны бүлэг, Соёлын биет бус өвийн төрөл зүйлийг таньж тогтоох, сурвалжлан олох;
- 3) Соёлын биет өвийн уламжилж буй байдал, шилжилт хөдөлгөөн, нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн нөхцөл байдлыг судлах;
- 4) Соёлын биет бус өвийн хадгалалт хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлж тогтоох, дүн шинжилгээ хийх;
- 5) Соёлын биет бус өв болон өвлөн уламжлагчийн тоо, газарзүйн тархалтыг тогтоох;
- 6) Соёлын биет бус өвийн чиглэлээр зохион байгуулагдсан арга хэмжээний мэдээллийг цуглуулах;
- 7) Соёлын биет бус өвийн үзлэг, судалгааны үр дүнгийн талаарх урьдчилсан дүгнэлт гаргах;
- 8) Үзлэг, судалгааны мөрөөр авах арга хэмжээний санал боловсруулах;

- 9) Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулж, Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг баяжуулах.

Судалгааны арга зүй

Судалгаанд хээрийн судалгааны арга болох

- Ярилцлага
- Мэдээлэл цуглуулах (судалгааны маягт бөглүүлэх)
- Ажиглалт
- Дүрслэлийн арга (дүрсжүүлэлт, фото зураг)
- Анализ буюу дүн шинжилгээ хийх

зэрэг аргыг уг судалгааны ажлын гол чиг баримжаа болгон ажиллав. Судалгаанд оролцогчдыг сонгохдоо Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд (СӨУНБМС)-д бүртгэлтэй соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдаас түүврийн аргаар сонгон судалгаанд хамруулав. Мөн сонирхсон өвлөн уламжлагчдад өвийн талаарх мэдээлэл олгож өвлөн уламжлагч тус бүр дээр бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага хийж, гэрэл зураг дүрс бичлэгээр баримтжуулав.

Судалгааны тойм (Нийслэлд хийгдсэн биет бус өвийн судалгаа)


Хээрийн судалгааг Соёлын Яамны № СоЯ-21/407 дугаартай захиалгат ажлын дагуу Соёлын өвийн үндэсний төв Төвийн бүсийн Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Улаанбаатар нийслэл /Хан-Уул, Баянгол, Сүхбаатар/ зэрэг аймаг, дүүрэгт нутагшиж байгаа соёлын биет бус өвийн эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд, Ардын язгуур урлаг, Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага, Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл, Уламжлалт арга ухаан, Мал маллах арга ухаан, Уламжлалт гар урлал зэрэг 7 ай савд хамаарах соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийг таньж тогтоох, мэдээлэл цуглуулах, өвлөн уламжлагчийн эзэмшсэн мэдлэг, авьяас билэг, ур чадварыг дуу, дүрс бичлэг хийж баримтжуулах хээрийн судалгааны ажлыг ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнтэй хамтран 2022 оны II сард хийсэн байна. Энэхүү хээрийн судалгааны ажлын үр дүнд нийт Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэгдсэн 5 ай савыг хамаарах УНБМСанд бүртгэлтэй 47, бүртгэлгүй 45 нийт 92 өвлөн өвлөн уламжлагчийг бүртгэж нийт 2691 ширхэг гэрэл зураг, 1341.092 GB дүрс бичлэгээр баримтжуулж Соёлын өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хадгалсан байна.

Судалгааны хамрах хүрээ

Нийслэлийн 9 дүүргийн соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг хамруулав.

Судалгааны маршрут

Соёлын биет бус өвийн үзлэг, хээрийн судалгааны ажлыг Нийслэлийн 9 дүүрэгт дараах маршрутын дагуу 2022 оны 10 дугаар сарын 26-ний өдрөөс 11 сарын 24 хүртэл 30 хоногийн хугацаанд зохион байгуулав.



Судалгааны ажлын үр дүнг ажлын даалгавар, судалгааны ажлын удирдамжид үндэслэн доорх байдлаар гаргав.

1	СББӨ-ийн уламжилсан байдал, шилжилт хөдөлгөөн, нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн нөхцөл байдлын судалгаа хийх;	-Дүүргийн ЗДТГын дарга болон соёл хариуцсан мэргэжилтэй уулзаж өнөөгийн нөхцөл байдлын талаар тодруулга авч, зөвлөгөө өгч ажиллав. -СББӨ-ийн 100 өвлөн уламжлагчаас цаасан болон цахим судалгааг авч судалгааг онлайн хэлбэрт бүртгүүлэв.
2.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Бүртгэл шинэчлэн батлах тухай” 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/759 дүгээр тушаалаар баталсан Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл, Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд бүртгэгдсэн өв, өвлөн	Монгол улсын биет бус соёлын өвийн төлөөллийн үндэсний бүртгэийн 6 ай савд хамаарах 38 өвийн 93 өвлөн уламжлагч, Яаралтай хамгаалах шаардлагатай Соёлын биет бус өвийн 2 ай савд хамаарах 3 өвийн 7 өвлөн уламжлагчийг судалгаанд хамруулав.

	уламжлагчийн талаар түүвэр судалгаа хийх;	
3.	Тухайн орон нутагт оршин буй үндэстэн, угсаатны бүлэг, СББӨ-ийн төрөл зүйлийг таньж тогтоох, сурвалжлан олох;	-
4.	Соёлын биет бус өв, өв тус бүрийн хадгалалт хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлж тогтоох, дүн шинжилгээ хийх;	-СББӨ-ийн хадгалалт хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдалд, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг асуулга болон ярилцлагын аргаар тодруулав.
5.	СББӨ болон өвлөн уламжлагчийн тоо, газарзүйн тархалтыг тогтоох;	-
6.	Тухайн орон нутагт СББӨ-ийн чиглэлээр зохион байгуулагдсан арга хэмжээний мэдээллийг цуглуулах;	-
7.	СББӨ-ийн үзлэг, судалгааны үр дүнгийн талаарх урьдчилсан дүгнэлт гаргах;	Тайлангийн дэд бүлгээс үзнэ үү.
8.	Үзлэг, судалгааны мөрөөр авах арга хэмжээний санал боловсруулах;	Тайлангийн гуравдугаар бүлгээс үзнэ үү.
9.	СББӨ, өвлөн уламжлагчийг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулж, Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг баяжуулах.	<p>Нийт 749 минут буюу 12 цагийн хугацаатай үргэлжлэх 223.3 GB хэмжээтэй дүрс бичлэг, 1.72 GB хэмжээтэй 442 ширхэг гэрэл зураг дүрс бичлэг бүрдүүллээ. Нийт файлын хэмжээ 714 ширхэг бүхий 235 GB боллоо.</p> <p>Зураг авалтад ашигласан тоног төхөөрөмж Дүрс бичлэгийг Nikon D800, Nikon D7000 ашиглан Full HD 1080 болон 4K нягтаршил бүхий MOV, MP4 форматаар бичлэг хийж баримтжуулсан. Баримтжуулалт хийсэн бичлэгүүдийн монтажлан нэгтгэсэн.</p> <p>Гэрэл зургийг Nikon D800, Canon ашиглан JPEG, RAW форматаар ашиглан авлаа. Эдгээр ажлын файлуудыг тухайн төхөөрөмжүүдийн дээд хүчин чадалд тулгаж авсан бөгөөд цаашид бүтээл болгон ашиглахад хангалттай өндөр чанартай болно.</p>

Нэг: Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчдын өнөөгийн байдал

Аливаа үндэстэн, ястаны биет бус өв бол тухайн өв оршиж байгаа газар нутаг, орон зай, тухайн бүлгийн эрхэлдэг аж ахуй, төрөх ёс, хэл, соёл иргэншлийн түүхэн нөхцөл байдлаас үүдэн өөр өөрийн онцлогтой байдаг. Монголчуудын аж төрж ирсэн орон зай түүний оюуны сэтгэлгээ, биет бус өвийнх нь үндсэн онцлогийг тодорхойлж ирсэн.

Монгол үндэсний гэх тодотголтой уламжлалт зан заншил, зан үйл, баяр, наадмууд хэрэглэгдэх нь хумигдсаар мартагдахад хүрч байсан нь орчин цагийн нийтийн соёл, урлагийн урсгал хүч түрэн орж уламжлалт өв соёлыг бүдгэрүүлж байсан нь саяхан мэт боловч үндэсний бахархал сэргэж уламжлалт өвөө хадгалж хамгаалах нийгмийн таатай нөхцөл бүрдсэн билээ.

Монгол Улсын Үндсэн хууль, төрөөс баримтлах соёлын бодлогод соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах тухай заалтууд ихээр нэмэгдэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2019 онын 759 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар “Монгол улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”-д соёлын биет бус өвийн 7 ай савд хамаарах 83 өвийг багтааж баталсан нь монгол угсаатны бүлгүүд, бүс нутгийн өвөрмөц онцлог бүхий соёл өвийг давхар хадгалж хамгаалах бодлого багтжээ.

Монголчууд соёлын биет бус өвийн арвин их сантай. Тэдгээрийн зарим нь дэлхийн соёлын өвд бүртгэгдсээр байна. Тухайлбал: ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвд “Монгол ардын уртын дуу”, “Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг” (2008 он), “Монгол наадам”, “Монгол ардын хөөмэйн урлаг”, “Шувуулахуй буюу бүргэдээр ан хийх зан үйл” (2010 он), “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл” (2013 он), “Шагайн харваа” (2014 он), “Хөхүүрийн айраг исгэх уламжлал, холбогдох зан үйл” (2019 он), ЮНЕСКО-ийн яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвд “Монгол тууль” (2008 он), “Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлаг” (2009 он), “Монгол лимбэчдийн уртын дуу тоглох уламжлалт арга барил- битүү амьсгаа” (2011 он), “Монгол уран бичлэг” (2013 он), “Ингэ хөөслөх буюу ботго авахуулах зан үйл” (2015 он), “Уул овоо тахих зан үйл” (2017 он) тус тус бүртгүүлсэн нь нүүдэлчин монголчуудын бүтээн бий болгосон давтагдашгүй эдгээр өвүүд нь үнэ цэнэтэй бөгөөд монгол үндэстнээс нийт хүн төрөлхтний соёлын өв санд оруулсан хувь нэмэр хэмээн үнэлсэн хэрэг юм.

Өнөөгийн Монгол улсад 20 гаруй угсаатны бүлгийн соёл, тэдгээрийн салбар соёлын судалгаа хийгдэж байна. Сүүлийн 20-иод жил угсаатны бүлгүүдийн орон нутгийн шинжтэй соёлын болоод угсаа гарлын зааг ялгаа аажмаар арилж өөр хоорондоо ижилсэх, уусах явц түргэсч эхэлсэн нь монгол угсаатны дотор болж байгаа соёлын үйл явцыг нийгэм-соёлын антропологийн үүднээс судлахын зэрэгцээ биет бус оюуны соёлын өвийг хойч үедээ өвлүүлэн үлдээх арга хэмжээг эрчимтэй явуулах хэрэгтэйг сануулж байна.

Бид энэ хүрээнд өвлөн уламжлагчдын хүйс, нас, угсаатны бүлэг, хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал, орлогын эх үүсвэр, тухайн хүний өвлөн уламжилж буй өв нь өрхийн эдийн засагт санхүүгийн хувьд ямар үр нөлөөтэй байгааг авч үзлээ. Дээрх асуудлыг тоон болон ажиглалт, ярилцлагын аргаар цуглуулж дүн шинжилгээ хийв.

Нийслэлийн соёлын биет бус өвийн бүртгэл судалгааны ажилд дүүрэг тус бүр




СӨУНБМСанд бүртгэлтэй өвлөн уламжлагчдийн мэдээлэлд тулгуурлан нийслэлийн 9 дүүргээс Монгол улсын Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэлийн 6 ай савд хамаарах 36 өвийн 93 өвлөн уламжлагч, Яаралтай хамгаалах шаардлагтай 2 ай савд хамаарах 3 өвийн нийт 7 өвлөн уламжлагч нийт 100 өвлөн уламжлагчийг бүртгэл, судалгаанд хамруулав.

Доорхи судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагчдын 40 хувь нь дүүргийн нийгмийн ажилтан, соёлын өвийн ажилтны таньж тогтоосноор бүртгэгдсэн өвлөн уламжлагчид бөгөөд 8 хувь нь судлаачдын таньж тогтоосноор 16 хувь нь өөрийн хүсэлтээр бүртгэлд хамрагдсан байна. (Зураг:01)

СББӨ-ийн өвлөн уламжлагч бүртгэлд хамрагдсан байдал

- Өөрийн хүсэлтээр
- Судлаачдын таньж тогтоосноор
- Орон нутгийн бүртгэлийн ажилтны тогтоосноор
- Мэдэхгүй



1.1 СББӨ өвлөн уламжлагчийн угсаатны бүлгийн онцлог

Бүрэн эрхт Монгол улс нь монгол болон түрэг угсаатны олон бүлгийн хүн амаас бүрдсэн нэгэн нэгдмэл ард түмэнтэй улс билээ.

Ний хүн амын 95 хувийг Монгол Угсаатны олон бүлгүүд, 5 орчим хувийг түрэг угсаатны Казах, Тува нар эзэлдэг. Эрдэмтэн судлаачид монгол угсаа хүн амыг угсаа гарал, өвөрмөц өв соёлынх нь хувьд Төв монголчууд (Халх), Баруун монголчууд (Торгууд, Дөрвөд, Өөлд, Алтайн урианхай, Баяд, Захчин, Тува урианхай, Хотон, казах), Зүүн монголчууд (Буриад, Үзэчин, Барга, Хамниган), Хойт монголчууд (Цахар, Дархад, Цаатан) хэмээн үндсэн том дөрвөн бүлэгт хувааж үздэг. Эдгээр угсаатны бүлэг бүхий өнөөг хүртэл оршиж өвөрмөц соёл, тэр дундаа соёлын биет бус өвөө хадгалан ирж хамгаалж цаашид улам хөгжүүлсээр байгаа билээ.

Монголын ард түмний ийнхүү соёлын өв уламжлагчдын багагүй хэсэг нь эх орны нийслэл Улаанбаатар хотноо төвшин сууж, аж төрж байна. Иймээс Улаанбаатар хот бүхэлдээ монголын олон угсаатны соёлын өв уламжлалыг хадгалж, тээж, харуулсан өвөрмөц соёлын хот юм. Мөн өнгөрсөн зууны эхэн үеэс урьдын бий болсон хүрээ маягийн дуу, хөгжим соёлын уламжлал нийслэл хотод бас бий. Ийм уламжлалт малчин ардын болон хүрээ төвшний соёлын уг үндэс, язгуур угсааг хадгалсан нь Улаанбаатар хотын Соёлын биет бус өвийн өнөө цагийн онцлог тал болно. Энэ байдал нь бидний судалгааны явцад тод харагдаж байна.

1.2 СББӨ өвлөн уламжлагчдын нийгмийн асуудал

Монгол угсаатны бүлгүүдийн соёл нь угтаа нэгэн үндэстэй боловч хожмоо байгаль цаг уурын зохицол, засаг захиргааны өөрчлөлт зохион байгуулалт зэргээс үүдэлтэй өөр хоорондоо харилцан ялгаатай салбарлаж нэр, нэршил хэл, аялгууны хэд хэдэн төрөл болон төлөвшсөн ч эргээд нийтлэг хэлбэрт шилжин хөгжихөд онцын төвөг үгүй гэж хэлж болно. Монгол угсаатны явц нь нэгд, угсаа бүлгүүдийн хоорондын ижилсэлт, хоёрт, нийгэм, эдийн засаг, соёлын амьдралын бүх хэсэгт нэгдэж байгаагаар тодорхойлогдож, монголын утга зохиолын хэл нийт бүлгүүдийн

үндсэн хэл болж хувирсан явдал орон нутгийн ба нийтлэгүүдийн ялгааг арилган нийгмийн нэг төрөл соёл бүрэлдэн тогтоход зонхилох үүрэг гүйцэтгэж буй билээ. Соёлын биет бус өв нь утга зохиол, уран сайхны урлаг мэргэшлийн биеэ даасан хэмжээнд хөгжиж, нийт ард түмний уламжлалт оюуны соёлд эсрэг нөлөө үзүүлж, улмаар тэр нь үндэсний соёлын хөгжилд эргэн үйлчилж, түүний цаашдын хөгжлийг гүнзгийрүүлэх боломж өгч, хүмүүсийн ухамсар дахь өнгөрсөн нийгмийн заншил зуршлыг шинэ үеийн зан суртахууны соёлоор солих өөрөөр хэлбэл шинэ хүний төрх шинжийг бие хүнд төлөвшүүлж хэвшүүлэхэд зохих үүрэг гүйцэтгэж, угсаа соёлын нийтлэг бүрэлдэхэд шийдвэрлэх хүчин зүйл болж байна.

2. НИЙСЛЭЛИЙН СББӨ-Д ХИЙСЭН ЦАХИМ СУДАЛГААНЫ (GOOGLE FORMS) ҮЗҮҮЛЭЛТ

Нийслэлийн бүсийн тандалт судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагчийн тоо: 100

Зөвшөөрөл: Соёлын биет бус өвлөн уламжлагч нь Монгол Улсын нутагт амьдарч буй угсаатны бүлгийн соёлын биет бус өвийн өнөөгийн нөхцөл байдал, оршин тогтнох чадварыг тандан судлах, дүн шинжилгээ хийх энэхүү судалгааны зорилгыг ойлгож, хүлээн зөвшөөрч, асуумжийг бөглөсөн болно.

НЭГ. Ерөнхий судалгаа

Нийт судалгаанд хамрагдсан 100 өвлөн уламжлагчийн 83.3 хувь нь эрэгтэй, 16.7 хувь нь эмэгтэй байна. (Зураг:02)




Судалгаанд хамрагдсан СББӨ-ийг өвлөн уламжлагчийн үндэс, угсаа

Өвлөн уламжлагчдын угсаатны бүлгээр ангилан үзэхэд Халх угсаатны бүлгийн төлөөлөл нийт өвлөн уламжлагчдын 79 хувийг эзэлж байсан бол Буриад угсаатны бүлгээс 5 хувь, Казак угсаатны бүлгээс 1 хувь, Торгууд угсаатны бүлгээс 3 хувь, Дарьганга угсаатны бүлгээс 2 хувь, Хотон угсаатны бүлгээс 1 хувь, Захчин угсаатны бүлгээс 4 хувь, Дөрвөд угсаатны бүлгээс 2 хувь, Баяд угсаатны бүлгээс 1 хувь тус тус судалгаанд хамрагдсан байна. (Зураг 03)




График үзүүлэлтээр Халх 79 хувь, Буриад 5 хувь, Казак 1 хувь, Торгууд 3 хувь, Дарганга 2 хувь Хотон 1 хувь, Захчин 4 хувь, Дөрвөд 2 хувь, Баяд 1 хувь байна.


Судалгаанд 18 хүртэлх настай 2 хувь, 19-25 настай нь 0 хувь, 26-35 настай 9.0 хувь, 46--60 настай 17,0 хувь, 60-80 настай 62.0 хувь байгаа нь өндөр настай өвлөн уламжлагчдын эзлэх хувь их байгааг харуулж байна.




Судалгаанд хамрагдсан СББӨ-ийг өвлөн уламжлагчийн боловсролын байдал (Зураг 04)



Судалгаанд хамрагдсан 100 өвлөн уламжлагчаас 3 хувь нь бага, 10 хувь нь Бүрэн бус, 21 хувь нь Бүрэн дунд, 20 хувь нь Тусгай дунд, 46 хувь Дээд боловсролтой байна.(Зураг 05)




Судалгаанд хамрагдсан СББӨ-ийг өвлөн уламжлагчийн хөдөлмөр эрхлэлтийн байдал (Зураг 06)



Харин хөдөлмөр эрхлэлтийн хувьд 58 хувь нь тэтгэвэрийн насных 14 хувь нь төрийн байгууллагад, 7 хувь нь хувийг хэвшлийн байгууллагад, 2 хувь нь малчин, үлдсэн 15 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг.

Судалгаанд хамрагдсан СББӨ-ийг өвлөн уламжлагчийн төрийн өндөр дээд одон медалиар шагнагдсан байдал /39 хүн олон хариултыг сонгосон. (Зураг 07)



Судалгаанд хамрагдсан СББӨ-ийг өвлөн уламжлагч тухайн сумынхаа уугуул иргэн эсэх (Зураг 08)



Уугуул иргэд 35 хувь бөгөөд бусад аймгаас шилжин ирсэн өвлөн уламжлагч 65 хувь нь байна.

График үзүүлэлээр шилжиж ирээд 20-оос дээш жил амьдарч буй иргэний эзлэх хувь 47 хувь байна. (Зураг 09)



Соёлын биет бус өвийн авьяасаа өвлөн уламжилсан хэлбэрүүд /100 хариултаас/ (Зураг10)




Судалгаанд хамрагдсан 100 өвлөн уламжлагчийн 81 хувь нь СББӨ-ийг өвлүүлж байгаа, үлдсэн

19 хувь ньүгүй гэж хариулжээ.




Соёлын биет бус өвөө ямар хэлбэрээр өвлүүлдэг гэсэн асуултад шавь сургалтаар 28 хувь, албан болон танхимын сургалтаар 7 хувь, ахуй амьдрал дээр 42 хувь, бусад гэсэн асуулгад 8 хувь нь хариулсан байна. /85хүний хариултаар/ (Зураг11)




СББӨ-ийг өөрийн ойрын гэр бүлээс 37 хувь, шавь сургалтаар 10 хувь, танхимаар 10 хувь, бие дааж 33 хувь, төрөл садан, хамаатнаас 10 хувь нь өвлөж авсан гэж хариулсан байна. (Зураг12)

СББӨ-ийг өвлөн уламжлагчдын өвийг өвлөсөн байдлыг авч үзвэл: 1 дэх үеэс өвлөсөн нь 42 хувь, 2 дэх үеэс өвлөсөн 18 хувь, 3 дэх үеэс өвлөсөн 10 хувь, 1 дэх үеэс өвлөсөн 11хувийг тус тус эзлэж байна. (Зураг 13)



Судалгаанд оролцогчид эрүүл мэнддээ анхаардаг байдал (Зураг 14)




Судалгаанд оролцогчдын эрүүл мэндийн хяналтанд орсон эсэх. (Зураг 15)

Ямар зорилгоор эмчийн хяналтад ордог вэ?



Судалгаанд оролцогчийн 1 удаа эрүүл мэндийн үйлчилгээ хэдэн төгрөгөөр авдаг эсэх (Зураг 16)


Та эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхэд нэг удаадаа хэдэн төгрөг зарцуулдаг вэ



ХОЁР. Соёлын биет бус өвийн оршин тогтнох чадварыг тодорхойлох судалгаа


СББӨ-ийг өвлөн уламжлагчид, өвийг хойч үедээ өвлүүлэх ажлыг тогтмолжуулж байгаа эсэх (Зураг 17)

СББӨ-ийг хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, сургах ажлыг тогтмолжуулж чадсан уу?




Өвийг уламжлуулах арга барил өөрчлөгдсөн эсэх (Зураг 18)

Ямар шалтгааны улмаас хувиран өөрчлөгдсөн талаар



Харьяа засаг захиргааны нэгжээс танд дэмжлэг үзүүлдэг үү?




■ Тийм ■ Заримдаа ■ Үгүй ■ Мэдэхгүй

Харьяа засаг захиргааны нэгжээс дэмжлэг авдаг 10 хувь, Заримдаа 28 хувь, Үгүй 46 хувь, 13 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна. /100 хариултаас/(Зураг 19)

Судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагчдаас тусгай хэрэгцээт хүн байгаа эсэх (Зураг 20)

Та нийгмийн амьдралд чөлөөтэй оролцоход тусгай хэрэгцээний ямар нэг тохируулга шаардагддаг уу?



■ Тийм ■ Үгүй


Судалгаанд оролцогчдоос нийгмийн амьдралд чөлөөтэй оролцоход тусгай хэрэгцээний ямар нэгэн тохируулга шаардлагатай байгаа эсэх 26 тийм гэсэн байна.

Нийгмийн амьдралд чөлөөтэй оролцоход тусгай хэрэгцээний ямар нэгэн тохируулга шаарддаггүй гэж 26,7 хувь нь хариулсан бөгөөд тулгуур эрхтэний хөдөлгөөний бэрхшээлтэй 5, харааны 11, сонсгол хэл, ярианы 2, эпилепси 2,


хавсарсан 1, бусад гэсэн асуулгад 5 хүн тийм гэж хариулжээ. /26 хариултаас/ (Зураг 21)




Судалгаанд оролцсон өвлөн уламжлагчдийн угийн бичих хөтөлдөг эсэх /100 хариултаас/ (Зураг 22,23)




Таны хөтөлж буй угийн бичиг аль хэлбэрт хамаарах вэ? (Зураг 24,25)



Танд уламжлалт аргаар хөтөлж ирсэн угийн бичиг байдаг уу?




Угийн бичиг хөтлөх уламжлалт мэдлэгийг хэнд өвлүүлэн уламжлуулж байна вэ?



ГУРАВ. Соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа

СББӨ-ийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдалд байгалийн сөрөгөөр нөлөөлж буй хүчин зүйлс байгаа эсэх (Зураг 28)


3.1 СББӨ-ийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдалд байгалийн сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс



- Бэлчээрийн нөөц, даац
- Өвс, ургамлын гарц
- Отрын бүс нутаг
- Усны нөөц
- Байгалын ашиг шимийн хүртээмж
- Бусад


СББӨ-ийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдалд нийгмийн нөлөөллийн сөрөг хүчин зүйлс байгаа эсэх /100 хариултаас/ (Зураг 29)

**СББӨ-ийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдалд
нийгмийн нөлөөллийн эерэг хүчин зүйлс**



- Суурьшил, хотжилт
- Цахим хэрэглээ
- Бүтээлч үйлдвэрлэл
- Өвийн хувьсал шинэчлэл, хөгжил
- Технологийн шинэчлэл
- Соёл, угсаатны зүй, ахуйд түшиглэсэн аялал жуулчлал
- Бусад

**СББӨ-ийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдалд
нийгмийн нөлөөллийн сөрөг хүчин зүйлс**



- Суурьшил, хотжилт, газар олголт
- Цахим хэрэглээ
- Өвийн талаарх мэдлэг ойлголт дутмаг
- Гаднын соёлын нөлөөлөл
- Соёлын нийлэгжилт
- Техник тоног төхөөрөмжийн хэрэглээ
- Соёлын өвийн үнэ цэн буурах
- Язгуур хэв шинжээ алдсан
- Өвлөн уламжлагчийн үнэлэмждоогуур
- Уул уурхайн ашиглалтын нөлөөлөл
- Замын нөлөөлөл
- Дэд бүтцийн нөлөөлөл
- Ядуурал
- Улс төр
- Цар тахал
- Бусад



Судалгаанд оролцогчдын орлогын эх үүсвэр /100 хариултаас/

Өвлөсөн өв өрхийн эдийн засаг, санхүүд нөлөөлдөг байдал /100 хариултаас/
(Зураг 32)



2.1. Нийслэлийн СББӨ-д хийсэн судалгааны тоон үзүүлэлт
СӨУНБМСанд бүртгэлтэй нийслэлийн 1528 өвлөн уламжлагч бүртгэлтэй байна.

2.2. Нийслэлийн СББӨ-ийн ай, өвийн төрлүүдэд хийсэн судалгаа
Судалгаанд хамрагдсан Нийслэлийн СББӨ-ийн өвийн төрлийг хүснэгтээр
харуулбал:

Монгол улсын соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл		
№	СББӨ-ийн ай	Өвийн төрөл
1	Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд	Цол дуудлага -2 Ерөөл – 2 Магтаал – 3 Монгол уран бичиг – 4 Торгууд аман аялгуу – 2 Түргэн хэллэг – 1 Хэлц хэвшмэл үг хэллэг - 2
2	Ардын язгуур урлаг	Халх уртын дуу – 4 Богино дуу – 2 Урианхай богино дуу -1 Лимбэ хөгжим тоглох урлаг -1 Цохилуур хөгжим тоглох урлаг - 3 Монгол хөөмийн уламжлалт урлаг - 1
3	Уламжлалт баяр наадам, зан үйл, ёслол, тоглоом наадгай, уриа дуудлагын өв	Шагайн харваа – 6 Шагайгаар тоглох, наадах – 1 Үндэсний сур харваа – 1 Монгол шатар - 1
4	Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл	Монгол зурхай – 2 Хурдан морь сойх, уралдуулах мэдлэг – 2
5	Уламжлалт арга ухаан	Угийн бичиг хөтлөх монгол уламжлалт мэдлэг – 15 Каз хийх арга – 1 Цагаан идээ бэлтгэх уламжлалт арга - 3 Бариа заслын аргаар анагаах арга ухаан - 3
6	Мал маллах арга ухаан	-
7	Уламжлалт гар урлал	Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал – 3 Үндэсний нум сум урлал – 1 Буриад нум сум урлаач – 1 Буриад хувцасны уламжлалт урлал - 1 Монгол гутлын урлал – 1 Эсгий ширмэл урлал – 1 Уламжлалт нэхэх, сүлжих урлал – 2 Уламжлалт уран хатгамал, оёдлын урлал - 3

		Халх хувцасны уламжлалт урлал – 3 Монгол зургийн урлал – 3 Монголын уламжлалт модон эдлэлийн урлал – 5 Монгол дархны уламжлалт арга ухаан – 5 Зээгт наамлын уламжлалт урлал - 1
	Бүгд: 6 ай сав	36 өв
Монгол улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл		
№	СББӨ-ийн ай	Өвийн төрөл
1	Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд	-
2	Ардын язгуур урлаг	Захчин бие биелгээ – 2 Халх бий биелгээ - 2 Торгууд бий биелгээ – 1 Лимбэ хөгжмийг битүү амьсгаагаар тоглох урлаг – 1
3	Уламжлалт баяр наадам, зан үйл, ёслол, тоглоом наадгай, уриа дуудлагын өв	Халх хуримын ёс, зан үйл – 1 Төл авахуулах, ая дуудлага, зан үйл Ном бүтээх уламжлалт урлал- 1
4	Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл	-
5	Уламжлалт арга ухаан	
6	Мал маллах арга ухаан	-
7	Уламжлалт гар урлал	
	Бүгд: 2 ай сав	7 өв

Соёлын биет бус өвийн ай сав, төрөл зүйлийн жагсаалт

Дд	Соёлын биет бус өвийн ай сав	Соёлын биет бус өвийн төрөл зүйл	Өвлөн уламжлагчийн тоо
1	Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд	Цол дуудлага -2 Ерөөл – 2 Магтаал – 3 Монгол уран бичиг – 4 Торгууд аман аялгуу – 2 Түргэн хэллэг – 1 Хэлц хэвшмэл үг хэллэг - 2	16
2	Ардын язгуур урлаг	Халх уртын дуу – 4 Богино дуу – 2 Урианхай богино дуу -1 Захчин бие биелгээ – 2 Халх бий биелгээ - 2 Торгууд бий биелгээ - 1 Лимбэ хөгжим тоглох урлаг -1 Лимбэ хөгжмийг битүү амьсгаагаар тоглох урлаг – 1 Цохилуур хөгжим тоглох урлаг - 3 Монгол хөөмийн уламжлалт урлаг - 1	18
3	Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа, дуудлага	Шагайн харваа – 6 Шагайгаар тоглох, наадах – 1 Үндэсний сур харваа – 1 Төл авахуулах ая дуудлага, зан үйл – 1 Халх хуримын ёс, зан үйл – 1 Монгол шатар - 1	11
4	Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл	Монгол зурхай – 1 Хурдан морь сойх, уралдуулах мэдлэг – 2	3
5	Уламжлалт арга ухаан	Угийн бичиг хөтлөх монгол уламжлалт мэдлэг – 15 Каз хийх арга – 1 Цагаан идээ бэлтгэх уламжлалт арга - 3 Бариа заслын аргаар анагаах арга ухаан -2	21

6	Уламжлалт гар урлал	Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал – 3 Үндэсний нум сум урлал – 1 Буриад нум сум урлаач – 1 Буриад хувцасны уламжлалт урлал - 1 Монгол гутлын урлал – 1 Ном бүтээх уламжлалт урлал – 1 Эсгий ширмэл урлал – 1 Уламжлалт нэхэх, сүлжих урлал – 2 Уламжлалт уран хатгамал, оёдлын урлал - 3 Халх хувцасны уламжлалт урлал – 3 Монгол зургийн урлал – 3 Монголын уламжлалт модон эдлэлийн урлал – 5 Монгол дархны уламжлалт арга ухаан – 5 Зээгт наамлын уламжлалт урлал - 1	31
	6		100

Баримтжуулалт хийсэн өвлөн уламжлагчдын жагсаалт:

Д/д	Өвлөн уламжлагчийн нэр	Баримтжуулалт хийсэн газар	Өвийн нэр, төрөл	Соёлын биет бус өвийн ай сав	Гэрэл зургийн тоо, хэмжээ	Дүрс бичлэгийн хэмжээ, хугацаа
1	Д.Ганхуяг	УБ, Багануур дүүрэг	Монгол уран бичлэг	Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд	27ш, 132МВ	11,5GB, 00:49:28 сек
2	З.Ханджав	УБ, Багануур дүүрэг	Уртын дуу	Уламжлалт арга ухаан	5ш, 30,7МВ	7,57GB, 00:54:02 сек
3	Э.Ууганбаяр	УБ, Багануур дүүрэг	Арьс шир боловсруулах уламжлалт арга	Уламжлалт гар урлал	2ш, 13,2МВ	7,88GB, 00:55:00 сек
4	Б.Баянцогт	УБ, Багахангай дүүрэг	Арьс шир боловсруулах уламжлалт арга	Уламжлалт гар урлал	7ш, 46,9МВ	8,75GB, 01:00:21 сек

5	Д.Мягмарцэнд	УБ, Багахангай дүүрэг	Шагайн харваа	Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага	33ш, 228 МВ	6,44GB, 00:44:41 сек
6	С. Цэрэнлхам	УБ, Баянгол	Уламжлалт уран хатгамал, оёдлын урлал	Уламжлалт гар урлал	63ш, 443МВ	13GB, 01:24:45 сек
7	О. Эрдэнэчимэг	УБ, Баянгол	Эсгий ширмэл урлал	Уламжлалт гар урлал	45ш, 307МВ	10,4GB, 01:13:50 сек
8	А.Дагзмаа	УБ, Баянзүрх дүүрэг	Сур харвааны уухай	Ардын язгуур урлаг	131МВ	9,33МВ
9	Ш.Биндэръяа	УБ, Баянзүрх дүүрэг	Угийн бичиг	Уламжлалт арга ухаан	251МВ	16.1GB 01:00:23 сек
10	П. Туяацэцэг	УБ, Налайх дүүрэг	Малын гэдэс дотроор хоол хүнс бэлтгэх арга	Уламжлалт арга ухаан	41МВ	3,27GB 00:21:21 сек
11	Д. Батнасан	УБ, Налайх дүүрэг	Монгол уран бичлэг	Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд	87,4МВ	7,74GB, 00:54:08 сек
12	Т.Захан	УБ, Налайх дүүрэг	Каз хийх арга	Уламжлалт арга ухаан	150МВ	6,01GB 00:24:54 сек
13	С.Золбоо	УБ, Налайх дүүрэг	Захчин биелгээ	Ардын язгуур урлаг	92МВ	3,10GB 00:21:45 сек
14	Ж. Энхтөр	УБ,Налайх дүүрэг	Магтаал	Ардын язгуур урлаг	22МВ	2,88GB, 00:18:51 сек
15	Э. Хүрэлбаатар	УБ, Налайх дүүрэг	Уртын дуу	Ардын язгуур урлаг	6,78МВ	9,65GB, 01:08:43 сек
16	Ц. Доржсүрэн	УБ, Сонгинохайрхан дүүрэг	Бариа заслын аргаар анагаах арга ухаан	Уламжлалт арга ухаан	33,7МВ	6,37GB, 00:44:39 сек
17	Б. Сэмбэдорж	УБ, Сонгинохайрхан дүүрэг	Хотон биелгээ	Ардын язгуур урлаг	81,8МВ	8,27GB, 00:58:37
18	Б.Ганхуяг	УБ,	Ерөөл	Ардын	1ш,	5ш,

		Сонгинохайрхан	магтаал	язгуур урлаг	5,02MB	1,98GB, 00:13:02 сек
19	Рэнцэнбямба	УБ, Сонгинохайрхан	Бариа засал	Уламжлалт арга ухаан	4ш, 29,6 MB	9ш, 6,13 GB, 00:43:28 сек
20	С.Дашжамц	УБ, Сүхбаатар дүүрэг	Лимбэний битүү амьсгаа	Ардын язгуур урлаг	0	8ш, 9,55GB, 01:07:54 сек
21	Д. Балжинням	УБ, Сүхбаатар дүүрэг	Угийн бичиг	Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд	0	1ш, 1,77GB, 00:11:38 сек
22	Ч. Нарантуяа	УБ, Хан-Уул дүүрэг	Ерөөл магтаал	Ардын язгуур урлаг	0	7ш, 2,33GB, 00:13:23 сек
23	Ц.Хадаа	УБ, Хан-Уул дүүрэг	Монгол зурхай	Уламжлалт арга ухаан	0	4ш, 9,74GB, 01:10:03 сек
24	Б. Норовсамбуу	УБ, Чингэлтэй дүүрэг	Уран нугаралт	Ардын язгуур урлаг	9ш, 65MB	17ш 24,2GB, 01:52:59 сек
25	Л.Мягмарсүрэн	УБ, Чингэлтэй дүүрэг	Монгол дархны уламжлалт арга ухаан	Уламжлалт гар урлал	13ш, 90MB	10ш, 6.02GB, 00:39:11 сек
26	Б. Мягмарсүрэн	УБ, Чингэлтэй дүүрэг	Монголын уламжлалт модон эдлэлийн урлал	Уламжлалт гар урлал	10ш, 57,6MB	6ш, 7,40GB, 00:48:26 сек
27	Д. Уранчимэг	УБ, Чингэлтэй дүүрэг	Зээгт наамал	Уламжлалт гар урлал	97ш, 1,59GB	7ш, 13,2GB, 01:01:57 сек
	НИЙТ	-Эх хэл аман уламжлал илэрхийллүүд- 3 -Ардын язгуур урлаг- 9 -Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага-1 -Уламжлалт арга ухаан-7 -Уламжлалт гар урлал-7	442 ш 1,72GB, 813.05 MB	223,28GB 12 цаг		



**2.3. Улаанбаатар хотын СББӨ-ийн судалгаанд оролцогчид,
өвлөн уламжлагчид, товч танилцуулга /9-н дүүргээр/**

Багануур					
Багануур дүүрэгт 2022 оны 11 дугаар сарын 11-13-нд ажиллав. Тус дүүргээс үзлэг, судалгаанд Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд 1, Уламжлалт арга ухаан 1, Уламжлал гар урлал төрөлд 1, нийт 3 өвлөн уламжлагчийг баримтжуулалтад хамруулав.					
Дд	Ко д	Гэрэл зургийн код	Дүрс бичлэгий н код	Өвлөн уламжлагчийн баримтжуулалтын мэдээлэл	Өвлөн уламжлагчийн гэрэл зураг
1	Н. БН	Н.БН01	Н.БН01	Нэр: Д.Ганхуяг Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд Өвийн нэр: Монгол уран бичлэг Баримтжуулсан тухай мэдээлэл: Монгол уран зургийг өвлөж авсан тухай яриа, уран бичлэгийн зориулалтын цаасан дээр бичиж буй зураг, дүрс бичлэг, Д.Ганхуягийн гэрэл зураг	
2	Н. БН	Н.БН02	Н.БН02	Нэр: З.Ханджав Ай сав: Ардын язгуур урлаг Өвийн нэр: Уртын дуу Баримтжуулсан тухай мэдээлэл: Уртын дуу болон малын уриа дуудлагын тухай яриа дүрс бичлэг, З. Ханджав гэрэл зураг.	
3	Н. БН	Н.БН03	Н.БН03	Нэр: Э.Ууганбаяр Ай сав: Уламжлалт арга ухаан Өвийн нэр: Арьс шир боловсруулах уламжлалт арга Баримтжуулсан тухай мэдээлэл: Арьс боловсруулж буй дүрс бичлэг, хэрэгдэгдэхүүнний зураг Э.Ууганбаярын гэрэл зураг.	
Багахангай дүүрэг					
Багахангай дүүрэгт 2022 оны 11 дугаар сарын 14-16-нд ажиллав. Тус дүүргээс үзлэг, судалгаанд Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага ай сав хамаарах1, Арьс шир боловсруулах уламжлалт арга төрөлд хамаарах 1, нийт 2 өвлөн уламжлагчийг баримтжуулалтад хамруулав.					

4	Н. БХ	Н.БХ01	Н.БХ01	Нэр: Д.Мягмарцэнд Ай сав: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа, дуудлага Өвийн нэр: Шагайн харваа Баримтжуулсан тухай мэдээлэл: Шагайн харвааны дэг ёс, зан үйлийн тухай яриа, уухай болон зэмэг хэрэглэгдэхүүний зураг болон гэрэл зураг, дүрс бичлэг Д.Мягмарцэндийн зураг	
5	Н. БХ	Н.БХ01	Н.БХ01	Нэр: Б.Баянцогт Ай сав: Уламжлалт арга ухаан Өвийн нэр: Арь шир боловсруулах уламжлалт арга Баримтжуулсан тухай мэдээлэл: Арьсаар бүтээгдэхүүн хийж буй дүрс бичлэг, Б.Баянцогтын гэрэл зураг.	
Баянзүрх дүүрэг					
Баянзүрх дүүрэгт 2022 оны 10 дугаар сарын 28-29-нд ажиллав. Тус дүүргээс Ардын язгуур урлаг, Уламжлал арга ухааны төрөлд 2 ний 2өвлөн уламжлагчийг баримтжуулалтад хамруулав.					
6	Н. БЗ	Н.Б301	Н.Б301	Нэр: Ш.Биндэръяа Ай сав: Уламжлалт арга ухаан Өвийн нэр: Угийн бичиг Баримтжуулсан тухай мэдээлэл: Угийн бичгийн өөрийн хөтөлсөн бичээсийн тайлбар яриа, тэмдэглэгээ, хөтлөх аргын тухай яриа, дүрс бичлэг, гэрэл зураг О. Ш.Биндэръяагийн гэрэл зураг	
7	Н. БЗ	Н.Б302	Н.Б302	Нэр: А.Дагзмаа Ай сав: Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа, дуудлага Өвийн нэр: Сур харвааны уухай Баримтжуулсан тухай мэдээлэл: Өвийг хэрхэн өвлөн авсайн тухай яриа, сур хавааны уухайэ уриа дуудлага, Харвах техник дууны дүрс бичлэг, гэрэл зураг А.Дагзмаагийн гэрэл зураг	



Баянгол дүүрэг

Баянгол дүүрэгт 2022 оны 10 дугаар сарын 26-27-нд ажиллав. Тус дүүргээс Уламжлалт гар урлалын төрөлд нийт 2 өвлөн уламжлагчийг баримтжуулалтад хамруулав.

8	Н. БГ	Н.БГ01	Н.БГ01	<p>Нэр: С. Цэрэнлхам Ай сав: Уламжлалт гар урлал Өвийн нэр: Уламжлалт уран хатгамал, оёдлын урлал Баримтжуулсан тухай мэдээлэл: Уран хатгамалыг өвлөн авсан тухай яриа, хатгамал, зүү ороох, туузан хатгамалын бүтээл хийж буй дүрс бичлэг, гэрэл зураг, С. Цэрэнлхамын гэрэл зураг.</p>	
9	Н. БГ	Н.БГ02	Н.БГ02	<p>Нэр: О. Эрдэнэчимэг Ай сав: Уламжлалт гар урлал Өвийн нэр: Эсгий ширмэл урлал Баримтжуулсан тухай мэдээлэл: Эсгий хий арга технологи болон эсгийгээр бэлдэх, ширмэлийг дараалал, хийх аргын тухай яриа болон дүрс, бичлэг, гэрэл зураг, О. Эрдэнэчимэгийн гэрэл зураг</p>	

Налайх дүүрэг

Налайх дүүрэгт 2022 оны 11 дугаар сарын 14-18нд ажиллав. Тус дүүргээс Эх хэл аман уламжла, илэрхийллүүд 1, Ардын язгуур урлаг 3, Уламжлалт арга ухааны 2, нийт 6 өвлөн уламжлагчийг баримтжуулалтад хамруулав.

10	НН	НН01	НН01	<p>Нэр: П. Туяацэцэг Ай сав: Уламжлалт арга ухаан Өвийн нэр: Малын гэдэс дотроор хоол хүнс бэлтгэх арга Баримтжуулсан тухай мэдээлэл: Хонины гэдэс дотрыг цэвэрлэх хүнсэнд хэрэглэх тухай яриа, Гэдэс дотрийг цэвэрлэх дараалал нь бэлтгэж буй дүрс бичлэг, гэрэл зураг П. Туяацэцэгийн гэрэл зураг</p>	
11	НН	НН02	НН02	<p>Нэр: Д. Батнасан Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд Өвийн нэр: Монгол бичиг Баримтжуулсан тухай мэдээлэл: Монгол бичгээр бичиж өөрийн арга, онцлог талууд, өвлөж авсан тухай</p>	

				яриа, бичвэрийг бичиж буй дүрс бичлэг, гэрэл зураг Д. Батнасангийн гэрэл зураг	
12	НН	НН03	НН03	Нэр: Т.Захан Ай сав: Уламжлалт арга ухаан Өвийн нэр: Каз хийх арга Баримтжуулсан тухай мэдээлэл: Каз бэлтгэх жижг үйлдвэрлэл дээр хичгдсэн бичлэг, Казын мах бэлтгэх, хэрхэн хийх талаар дүрс бичлэг, гэрэл зураг О. Т.Заханы үйлдвэрлэлийн гэрэл зураг	
13	НН	НН04	НН04	Нэр: С.Золбоо Ай сав: Ардын язгуур урлаг Өвийн нэр: Захчин биелгээ Баримтжуулсан тухай мэдээлэл: Захчин бий биелгээний намба төрхийн яриа болон морин хуурын татлагтай хийсэн биелгээг дүрс бичлэг, гэрэл зургаар баримтжуулав.	
14	НН	НН05	НН05	Нэр: Ж. Энхтөр Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд Өвийн нэр: Магтаал Баримтжуулсан тухай мэдээлэл: Магтаал дүрс, бичлэг, гэрэл зураг,	
15	НН	НН06	НН06	Нэр: Э. Хүрэлбаатар Ай сав: Ардын язгуур урлаг Өвийн нэр: Уртын дуу Баримтжуулсан тухай мэдээлэл: Уртын дуу, морины цолыг дүрс бичлэг, гэрэл зургаар баримтжуулав. Э. Хүрэлбаатарийн гэрэл зураг	
Сонгинохайрхан дүүрэг					
Сонгинохайрахн дүүрэгт 2022 оны 11 дугаар сарын 7-9 нд ажиллав. Тус дүүргээс Ардын язгуур урлаг 2, Уламжлалт арга ухааны 2, нийт 4 өвлөн уламжлагчийг баримтжуулалтад хамруулав.					
16	НС Х	НСХ01	НСХ01	Нэр: Ц. Доржсүрэн Ай сав: Уламжлалт арга ухаан Өвийн нэр: Бариа заслын аргаар анагаах арга ухаан Баримтжуулсан тухай мэдээлэл: тухай яриа болон дүрс, бичлэгээр баримтжуулав. Ц. Доржсүрэн гэрэл зураг	

17	НС Х	НСХ02	НСХ02	<p>Нэр: Б. Сэмбэдорж Ай сав: Уламжлалт гар урлал Өвийн нэр: Эсгий ширмэл урлал Баримтжуулсан тухай мэдээлэл: : Захчин бий биелгээний намба төрхийн яриа болон морин хуурын татлагтай хийсэн биелгээг дүрс бичлэг, гэрэл зургаар баримтжуулав. Б. Сэмбэдорж гэрэл зураг</p>	
18	НС Х	НСХ03	НСХ03	<p>Нэр: Д. Рэнцэнбямба Ай сав: Уламжлалт арга ухаан Өвийн нэр: Бариа заслын аргаар анагаах арга ухаан Баримтжуулсан тухай мэдээлэл: Уламжлалт аргаар барих арга, өвийг өвлөж авсан тухай, барианд хэрэглэх тарни зэргийг дүрс бичлэг, гэрэл зургаар баримтжуулав. Д. Рэнцэнбямба гэрэл зураг</p>	
19	НС Х	НСХ04	НСХ04	<p>Нэр: Б.Ганхуяг Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд Өвийн нэр: Магтаал, ерөөл Баримтжуулсан тухай мэдээлэл: Гэрийн ерөөл, хуримын, хүүхдийн сэвлэг үргээх ерөөлийг дуудаж дүрс бичлэг, гэрэл зургаар баримтжуулав. Б. Ганхуягын гэрэл зураг</p>	
<p>Сүхбаатар дүүрэг</p>					
<p>Сүхбаатар дүүрэгт 2022 оны 11 дугаар сарын 10-12нд ажиллав. Тус дүүргээс Ардын язгуур урлаг 2, Уламжлалт арга ухааны 1, нийт 3 өвлөн уламжлагчийг баримтжуулалтад хамруулав.</p>					
20	НС	НС01	НС01	<p>Нэр: С.Дашжамц Ай сав: Ардын язгуур урлаг Өвийн нэр: Лимбэ хөгжмийн битүү амьсгаагаар тоглох арга Баримтжуулсан тухай мэдээлэл: Лимбэ хөгжмийг гинжин амьсгаагаар монгол ардын 5-8 дууг тоглосон дүрс бичлэг, гэрэл зураг С.Дашжамцын гэрэл зураг</p>	

21	НС	НС02	НС02	<p>Нэр: Д. Балжинням Ай сав: Уламжлалт арга ухаан Өвийн нэр: Угийн бичиг хөтлөх монгол уламжлалт мэдлэг Баримтжуулсан тухай мэдээлэл: Өөрийн хөтөлсөн угийн бичгийн арга барлийн талаар дүрс бичлэг, угийн бичгийн ном гаргасан тухай дурьдсан тэмдэглэлийг гэрэл зургаар баримтжуулалт хийв. Д.Балжинням гэрэл зураг</p>	
22	НС	НС03	НС03	<p>Нэр: Ч. Нарантуяа Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд Өвийн нэр: Магтаал Баримтжуулсан тухай мэдээлэл: Гэрийн магтаалтай холбоотой зан үйл, өөрийн сурсан 4-5 магтаалын уншиж дүрс бичлэг, гэрэл зургаар баримтжуулалт хийв. Ч. Нарантуяагийн гэрэл зураг</p>	
<p>Хан- Уул дүүрэг</p>					
<p>Хан- Уул дүүрэгт 2022 оны 11 дугаар сарын 05-07нд ажиллав. Тус дүүргээс Ардын язгуур урлаг 1, Уламжлалт гар урлал 3, нийт 4 өвлөн уламжлагчийг баримтжуулалтад хамруулав.</p>					
23	НХ У	НХУ01	НХУ01	<p>Нэр: Ц.Хадаа Ай сав: Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл Өвийн нэр: Монгол зурхай Баримтжуулсан тухай мэдээлэл: Одон зурхайн үүсэл, хөтлөх арга, холбогдох зан үйл амьдралд хэрэглэж байсан түүх уламжлалын талаар видео бичлэг, гэрэл зураг Ц. Хадааны зураг</p>	
24	НХ У	НХУ02	НХУ02	<p>Нэр: Л.Мягмарсүрэн Ай сав: Уламжлалт гар урлал Өвийн нэр: Монгол дархны уламжлалт арга ухаан Баримтжуулсан тухай мэдээлэл: Монгол дархын урлал хийх багаж, зэмсэг, өөрийн арга, болон өвийг өвлөж авсан тухай яриа дүрс бичлэг, гэрэл зураг Л. Мягмарсүрэнгийн гэрэл зураг</p>	

25	НХ У	НХУ03	НХУ03	<p>Нэр: Б.Мягмарсүрэн Ай сав: Уламжлалт гар урлал Өвийн нэр: Монголын уламжлалт модон эдлэлийн урлал Баримтжуулсан тухай мэдээлэл: Модоор гэрийн тавилга, хийх арга, мод бэлтгэх 6 төрлийн машинд хэрхэн модыг бэлтгэх аргыг дүрс бичлэг, гэрэл зургаар баримтжуулалт хийв. Б. Мягмарсүрэнгийн гэрэл зураг</p>	
26	НХ У	НХУ04	НХУ04	<p>Нэр: Д. Уранчимэг Ай сав: Уламжлалт гар урлал Өвийн нэр: Зээгт наамлын уламжлалт урлал Баримтжуулсан тухай мэдээлэл: Зээгт наамал тухай өөрийн арга барил болон наамалын зураг болон эскиз гаргах, эсгэх, зээг утас бэлдэх хялбаршуулсан аргыг шинээр санаачилсан зэрэг талаар яриаг дүрс бичлэг, гэрэл зургаар баримтжуулсан. Зоосон ширээ хийх аргачлалын зургаар . О. Эрдэнэчимэгийн гэрэл зураг</p>	
<p>Чингэлтэй дүүрэг</p> <p>Чингэлтэй дүүрэгт 2022 оны 11 дугаар сарын 13 нд ажиллав. Тус дүүргээс Ардын язгуур урлагийн ай савд хамаарах 1 өвлөн уламжлагчийг баримтжуулалтад хамруулав.</p>					
27	НЧ	НЧ01	НЧ01	<p>Нэр: Б. Норовсамбуу Ай сав: Ардын язгуур урлаг Өвийн нэр: Уран нугаралт Баримтжуулсан тухай мэдээлэл: Уран нугаралтын техник, дасгалын дэс дараалал, анхаарах болон хориглох зүйл, аюулгүй ажиллагааны талаар яриа болон уран нугаралтыг видео дүрс бичлэг, гэрэл зургаар баримтжуулав.</p>	

ЗӨВЛӨМЖ

-Өвлөн уламжлагч, хамт олон бүлэг хүмүүс өөрсдийн соёлын биет өвөөрөө хөдөлмөр эрхэлдэг хүмүүс олон байдаг. Эдгээр өвлөн уламжлагчдад өрхийн орлогоо нэмэгдүүлэх, бүтээгдэхүүнээ эргэлтэд оруулах санхүүгийн эх үүсвэртэй болох төрийн дэмжлэг үгүйлэгдэж байна.

- Ерөнхий боловсролын сургуулийн цахим хичээлийн платформд Соёлын өвийн талаарх мэдлэг, ойлголт олгох хичээл хязгаардмал (1-2 сэдвийн хүрээнд) цөөн байгааг мэргэжлийн сургагч багш, судлаачид онцолж үүнийг бага, дунд, ахлах ангид тэнцвэртэйгээр байршуулж ЕБС-ийн түвшинд сурталчлах шаардлагтай байна.

- Өвлөн уламжлагч нар “Өвлөн уламжлагч”- аар бүртгүүлэх хүсэлтээ хаана, ямар хэлбэрээр гаргах талаар мэдлэг ойлголт сул байгаа нь иргэдийн соёлын өвийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээлэлээр хангах ажлыг сайжруулах шаардлагтайг харуулж байна.

- Аймаг, нийслэлийн бүртгэл мэдээллийн сангийн СББӨ-ийн бүртгэлд шинээр өвлөгчийг таньж тогтоох, бүртгэх ажлыг тухайн сум, дүүргийн ЗДТГ-ын дэргэдэх орон тооны бус зөвлөлөөр хэлэлцүүлэн бүртгэж авах ажил тогтмолжоогүй орхигдсон хэвээр байна.

САНАЛ

- Нийслэлийн дүүргүүд “Соёлын биет бус үзлэг, бүсчилсэн судалгаа”-ны талаарх өвлөн уламжлагчдад мэдээлэл хүргэх, цуглуулах, баримтжуулах ажлыг хангалтгүй зохион байгуулсныг дурьдах нь зүйтэй.
- Салбарын шат шатны байгууллагууд “Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгаа” -ны ажилд дүн шинжилгээ хийж үзлэгийн мөрөөр арга хэмжээг авч тайлагнадаг байх.
- Аймаг, нийслэлийн Соёлын байгууллагын ажилтан (музейн БМСанч) ажлаас гарах, дэвших зэргээр солигдож байгаатай холбоотой бүртгэл мэдээллийн сангийн хадаглалтийн аюулгүй байдал сул байна. (БМСангийн мэдээлэл устаж алга болох тохиолдол гарсаар байна.) Иймд БМСангийн хадаглалтын аюулгүй байдал хяналт тавьдаг байх.
- СББӨ-ийн Улсын үзлэгт тооллогод шаардлагтай тоног төхөөрөмжөөр хангах, шаардлагтай.
- Засгийн газрын 2018 оны 354 дүгээр тогтоолын хавсралт “Соёлын биет бус өвийг сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам”-аар нэг жилд 1 хүнд олгодог 30 сая төгрөгийн урамшуулалыг 2-3 хүнд хуваан олгохоор өөрчлөх зэрэг саналыг өвлөн уламжлагчид тавьж байна.

НОМ ЗҮЙ

1. Н. Уртнасан 2017. “Соёлын биет бус өвийн лавлах”
2. Халхын угсаатны зүйн эх хэрэглэгдэхүүн, 2020
3. СББӨ-ийг хамгаалах тухай 2003 оны конвенцийн үндсэн баримт бичгүүд, 2011
4. Ц. Гантулга, М. Ганбол, Т. Лхагваа. 2012. “Урианхай түмний түүх соёл”
5. Монголын угсаатны зүйн Хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн УБ.,2011, 1-10 боть
6. “Нийслэл хот дах угсаатан зүйн онцлог” Эх сурвалж Цэрэнханд Гэлэгжамцын , Маралмаа Нагаанбуу “Монголын угсаатны зүйн судалгаа ба орчин үе” (Этнографические исследования в Монголии на современном этапе), хуу 5-6
7. “Нийслэлийн хүн амын үзүүлэлт” Эх сурвалж Нийслэлийн статискийн газар. <http://ubstat.mn/Home%20page> Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв <https://ecrc.mn/dci-article/>